



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/11/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор:	Х.Түвшинбаяр
	Утас: 70483413 Цахим хаяг:	tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг:	erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Ж.Бүжинханд
	Утас: 99177546 Цахим хаяг:	Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор:	С.Санчирмаа
	Утас: 99282488 Цахим хаяг:	sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ ...	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/	8
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	11
3.5.1 Орлогын данс	12
3.5.2 Зардлын данс	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 184
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



07020499

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	606,148.8	1,034,724.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	195,663.9	266,653.4
33	АВЛАГА	98,413.6	202,328.1
35	БАРАА МАТЕРИАЛ	274,105.6	433,244.3
36	НӨӨЦИЙН БАРАА	18,476.0	15,142.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	19,489.7	117,356.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,206,231.3	3,854,000.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,206,231.3	3,854,000.3
39200	Биет хөрөнгө	3,160,335.2	3,796,424.4
39300	Биет бус хөрөнгө	45,896.1	57,575.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,812,380.0	4,888,725.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,603.7	12,415.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,603.7	12,415.0
41300	Өглөг	15,603.7	12,415.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,796,776.3	4,876,310.2
51	Засгийн газрын хувь оролцоо	3,796,776.3	4,876,310.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,818,503.3	2,212,319.0
51200	Хуримтлагдсан үр дүн	1,288,914.7	1,944,916.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	689,358.2	719,075.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,812,380.0	4,888,725.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,741,019.6	3,347,233.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	85,987.7	84,698.5
110	Орлогын албан татвар	66,781.5	65,775.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,781.5	65,775.9
113	Хөрөнгийн албан татвар	2,672.0	1,848.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,534.2	17,074.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	340,132.6	762,148.0
120	Нийтлэг татварын бус орлого	340,132.6	753,398.0
122	Тусламжийн орлого	0.0	8,750.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,314,899.3	2,500,387.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,627,925.0	2,752,412.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,627,925.0	2,752,412.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,916,701.7	2,646,766.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,211,876.3	1,565,616.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,026.8	211,464.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,638.7	111,554.3
2104	Хангамж, бараа материалын зардал	46,931.2	225,244.1
2105	Нормативт зардал	29,855.3	79,903.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,372.0	9,507.6
2107	Томилолт, зочны зардал	8,108.6	6,653.2

Аудитын код: ГАА-2022/11/-НА-СТА-ТТЗ

Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,476.5	16,973.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	273,416.3	419,850.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	711,223.4	105,646.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	113,094.6	594,821.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	90,460.0	30,502.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	22,634.6	564,319.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,521,030.5	2,617,097.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	85,987.7	84,698.5
110	Орлогын албан татвар	66,781.5	65,775.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,781.5	65,775.9
113	Хөрөнгийн албан татвар	2,672.0	1,848.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,534.2	17,074.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,876.2	7,490.1
1181	Газрын төлбөр	10,525.2	9,575.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	132.8	9.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,193.5	81,625.8
120	Нийтлэг татварын бус орлого	101,193.5	81,625.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,333,849.3	2,450,773.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,341,224.6	2,302,129.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,341,224.6	2,302,129.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,611,054.0	2,196,077.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,206,911.3	1,567,833.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,394.8	212,338.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,880.6	116,511.2
2104	Хангамж, бараа материалын зардал	44,249.4	90,193.6
2105	Нормативт зардал	25,308.2	112,116.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,575.9	21,443.8
2107	Томилолт, зочны зардал	8,108.6	6,653.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,965.0	28,795.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,660.1	40,192.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	730,170.6	106,051.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	179,805.9	314,968.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	102,907.6	153,979.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	102,907.6	153,979.1
2200	Дотоод эх үүсвэрээр	102,907.6	153,979.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-102,907.6	-153,979.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-41,600.0	-90,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	41,600.0	90,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	35,298.2	70,989.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	160,365.6	195,663.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	195,663.9	266,653.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,775,079.7	0.0	3,775,079.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-938.0	0.0	-938.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,774,141.7	0.0	3,774,141.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	22,634.6	0.0	22,634.6
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,796,776.3	0.0	3,796,776.3
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,796,776.3	0.0	3,796,776.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	515,215.0	0.0	515,215.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,311,991.3	0.0	4,311,991.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	564,319.0	0.0	564,319.0
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,876,310.2	0.0	4,876,310.2


2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,632,699.70	2,370,780.41	261,919.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,335,161.70	2,175,057.01	160,104.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,304,861.50	2,146,811.06	158,050.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,630,527.20	1,532,722.38	97,804.82
210101	Үндсэн цалин	1,166,232.70	1,127,267.78	38,964.92
210102	Нэмэгдэл	114,000.00	78,839.83	35,160.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,400.00	5,115.00	2,285.00
210104	Урамшуулал	154,936.50	140,024.66	14,911.84
210105	Гэрээт ажлын хөлс	187,958.00	181,475.11	6,482.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	224,999.80	207,922.12	17,077.68
210201	Тэтгэврийн даатгал	157,940.90	144,202.16	13,738.74
210202	Тэтгэмжийн даатгал	16,055.10	16,017.55	37.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,827.10	12,526.39	1,300.71
210204	Ажилгүйдлийн даатгал	3,380.40	3,615.95	(235.55)
210205	Эрүүл мэндийн даатгал	33,796.30	31,560.07	2,236.23

Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	124,612.20	116,511.15	8,101.05
210301	Гэрэл, цахилгаан	18,325.20	13,763.28	4,561.92
210302	Түлш, халаалт	99,100.00	96,006.00	3,094.00
210303	Цэвэр, бохир ус	7,187.00	6,741.88	445.13
2104	Хангамж, бараа материалын зардал	76,871.80	69,022.59	7,849.21
210401	Бичиг хэрэг	7,207.00	6,790.90	416.10
210402	Тээвэр, шатахуун	42,117.10	36,345.46	5,771.64
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,171.10	5,779.21	1,391.89
210404	Ном, хэвлэл	661.30	648.90	12.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,202.20	8,971.50	230.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,513.10	10,486.62	26.48
2105	Нормативт зардал	93,343.30	88,186.47	5,156.83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,670.00	40,669.72	0.28
210502	Хоол, хүнс	42,268.30	37,128.25	5,140.05
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,405.00	10,388.50	16.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,133.40	69,144.52	10,988.88
210601	Багаж, техник, хэрэгсэл	41,234.40	36,965.52	4,268.88
210602	Тавилга	14,524.00	7,810.00	6,714.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,190.00	2,184.00	6.00
210604	Урсгал засвар	22,185.00	22,185.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	9,329.00	6,370.90	2,958.10
210702	Дотоод албан томилолт	9,329.00	6,370.90	2,958.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,164.00	20,009.98	4,154.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,072.00	17,002.76	3,069.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648.00	648.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	610.00	438.90	171.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450.00	164.91	285.09
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	270.00	143.50	126.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	760.00	760.00	-
210807	Газрын төлбөр	235.00	163.62	71.38
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	961.00	688.30	272.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,880.80	36,920.95	3,959.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,709.70	33,853.85	3,855.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,171.10	3,067.10	104.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,300.20	28,245.95	2,054.25

Аудитын код: ГАА-2022/11/-НА-СТА-ТТЗ



2132	Бусад урсгал шилжүүлэг	30,300.20	28,245.95	2,054.25
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,190.20	16,572.45	1,617.75
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,110.00	11,673.50	436.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	143,551.30	105,723.40	37,827.90
223001	Бусад хөрөнгө	143,551.30	105,723.40	37,827.90
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	153,986.70	90,000.00	63,986.70
230001	Эргэж төлөгдөх зээл	153,986.70	90,000.00	63,986.70
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,632,699.70	2,427,040.65	205,659.05
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,658,660.20	1,619,254.94	39,405.26
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,658,660.20	1,619,254.94	39,405.26
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	760,077.80	725,446.04	34,631.76
320001	Орон нутгийн төсвөөс	619,761.10	585,129.34	34,631.76
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	140,316.70	140,316.70	-
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,953.60	5,711.86	17,241.74
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,953.60	5,711.86	17,241.74
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	191,008.10	76,627.80	114,380.30
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,686.80	55,649.89	(2,963.09)
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000.00	20,977.91	(5,977.91)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	123,321.29	(123,321.29)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	179,581.52	(179,581.52)

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	142,203.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,203.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,522.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,110.85
210101	Үндсэн цалин	35,110.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,416.51
210201	Тэтгэврийн даатгал	4,416.51
2104	Хангамж, бараа материалын зардал	21,171.00
210401	Бичиг хэрэг	527.00
210402	Тээвэр, шатахуун	1,774.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,320.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000.00
2105	Нормативт зардал	23,930.38

Аудитын код: ГАА-2022/11/-НА-СТА-ТТЗ

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,942.88
210502	Хоол, хүнс	2,987.50
2107	Томилолт, зочны зардал	282.32
210702	Дотоод албан томилолт	282.32
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,785.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,785.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,826.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,986.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,680.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,280.55
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,280.55
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	142,464.61
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	142,464.61
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,089.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,204.01
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,500.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	78,671.20
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	261.55
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	261.55

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төгрөг сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн

Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 1/76 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн Засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангахад оршино” гэсэн эрхэм зорилго тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Иргэдийн оролцоо зөв засаглал
- Дэд бүтцийн бодлого
- Байгаль орчин аялал жуулчлал
- Хүний хөгжил нийгмийн бодлого
- Гэр бүл, хүн ам, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал
- Эрүүл мэнд, биеийн тамир, спорт
- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,138.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 42.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 34.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 3,406.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 68.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 54.5 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28 хувиар буюу 1,076.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 195.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 266.6 сая төгрөг болж, 70.9 сая төгрөгөөр өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгө нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа бөгөөд үүний 24 хувь болох 63.5 сая төгрөг нь сумын ерөнхий орлогын, 9 хувь болох 23.3 сая төгрөг нь байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн сангийн, 26 хувь болох 68.3 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн, 15 хувь болох 40.0 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 27 хувь болох 71.5 сая төгрөг нь эрүүл мэндийн төвийн дансанд байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 98.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 208.6 сая төгрөг болж, 110.2 сая төгрөгөөр өссөн. Авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 52.5 сая төгрөгийн, ОНХС-ийн 14.1 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэхтэй холбоотой ЗДТГ-ын 6.3 сая төгрөгийн, байгууллагаас авах авлага 52.5 сая төгрөгийн эрүүл мэндийн төвийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна. Байгууллагаас авах авлага нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн эргэлтийн хөрөнгийн түргэн хөрвөх чадварыг бууруулж цаашид төлөгдөхгүй тохиолдолд үргүй зардал бий болох сөрөг үр дагавартай.

Бараа материалын эхний үлдэгдэл 274.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 433.2 сая төгрөг болж, 159.1 сая төгрөгөөр өссөн, эм боох материал эхний үлдэгдэл 0.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 38.6 сая төгрөг болж, 38.4 сая төгрөгөөр өссөн, хангамжийн материал эхний үлдэгдэл 99.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 208.4 сая төгрөг болж 109.1 сая төгрөгөөр

өссөн, борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө 117.3 сая төгрөг болж тайлант хугацаанд нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал 62 хувь буюу 389.2 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн бол 24 хувь буюу 153.1 сая төгрөгийн бараа материалыг хандиваар, 14 хувь буюу 82.9 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан бол 469.4 сая төгрөгийн бараа материал хасагдаж оны эцэст 433.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,206.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,854.0 сая төгрөг болж, 647.8 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 48.2 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 8.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хандиваар, 1,401.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авснаар нийт 1,457.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 114.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 149.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн нийт 264.2 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөд 396.4 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан ба шилжүүлсэн болон акталсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл болох 241.8 сая төгрөгийг дансны хасалт хэсэгт тайлагнасан байна.

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 18.7 сая төгрөг болж, 3.1 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 6.3 сая төгрөгийн орон нутгийн ерөнхий орлого хөрөнгийн өглөг, 12.4 сая төгрөгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн өглөгийн бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,796.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,876.3 сая төгрөг болж, 1,079.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 22 хувиар буюу 606.2 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү (0.9) сая төгрөгөөр хаасан бичилт хийсэн ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 4,876.3 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 84.7 сая төгрөгийн татварын орлого, 762.1 сая төгрөгийн татварын бус орлого, 2,500.4 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,347.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 2,752.4 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 30.5 төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төгрөг сумын ИТХ-ын 2021 оны 12 дүгээр сарын “Сумын 2021 оны төсөвт тодотгол хийж нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 11 дүгээр тогтоолд зааснаар Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 65.4 сая төгрөгийн татварын, 2.8 сая төгрөгийн татварын бус нийт 68.2 төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас

гүйцэтгэлээр 88.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 130 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс орлого тасраагүй байна.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг харьяа байгууллагуудын хувьд тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,632.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,175.1 сая төгрөгийг урсгал зардалд, 105.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,619.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 725.4 сая төгрөгийн, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 5.7 сая төгрөгийн, төсөвт байгууллагын өөрийн орлого 76.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,370.8 сая төгрөгийг зарцуулж 16.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,370.8 сая төгрөг буюу 90 хувьтай байгаа нь 165.8 сая төгрөгөөр, цалин хөлс 34.9 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн 4.4 сая төгрөгөөр, хангамжийн бараа материал 18.6 сая төгрөгөөр, нормативд зардал 23.9 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардалд 16.8 сая төгрөгөөр, томилолт, зочны 0.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх 16.1 сая төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 0.8 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 142.5 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан 4.1 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 57.2 сая төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас 2.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 78.7 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. 0.3 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Нэмэлт санхүүжилтийн орлогыг цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол, хангамж бараа материал, нормативд, эд хогшил, урсгал засвар,

томилолт, бусдаар гүйцэтгүүлэх, нэг удаагийн тэтгэмж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим хуудсанд түүвэрлэн үзэхэд оруулбал зохих 25 мэдээллээс 24 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба 1 орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хоцроон мэдээлсэн.

Төгрөг сумын ИТХ нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс 1 төрлийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32.9 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг хоцроон мэдээлсэн.

Төгрөг сумын Соёлын төв нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс 1 төрлийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16.5 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг хоцроон мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 10.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 18.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангаар өгөгдсөн шийдвэрээс 0.7 сая төгрөгийн төлбөрийн акт хэрэгжилтийг хангуулаагүй байна.

Хэрэгжээгүй шийдвэрийн тухайд байгууллагын удирдлагад биелэлт ирүүлэх албан бичиг хүргүүлсэн төдийгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна.

Аудитын код: ГАА-2022/11/-НА-СТА-ТТЗ

Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлага, өглөгийн барагдуулалт, аудитын шийдвэрийг хэрэгжилт, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4, “Хязгаарлалттай” 1, дүгнэлт өгсөн байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 107.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 20.5 сая төгрөгийн алдааг залруулж, 14.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 72.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг өгөгдсөн хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 0.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 0.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон түүвэрт хамрагдсан байгууллагад залруулга хийгдээгүй.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төлбөрийн акт тогтоогоогүй.

Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

Төгрөг сумын Соёлын төв

Төсөв захирагч нь өөртөө тушаал гарган 0.2 сая төгрөгийн хоолны мөнгө авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Үндэслэлгүйгээр 0.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 0.2 сая төгрөгийн амралтын цалин авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ийн 2.5-т "Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээгүй.

Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

Төгрөг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт " Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төгрөг сумын Соёлын төв

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 0.1 сая төгрөгийн зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт " Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон түүвэрт хамрагдсан байгууллагад аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
Төгрөг сумын Төвлөрүүлэн захирагч											
Түүвэрт хамрагдсан байгууллага											
	Соёлын төв	4	0.8			2	0.7	2	0.1		
	ИТХ	1						1			
	Дүн	5	0.8			2	0.7	3	0.1		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
	Дүн										
	Соёлын төв										
	ИТХ										
	Дүн										
	Нийт дүн	5	0.8			2	0.7	3	0.1		5